



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн өмчийн
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуучин барилгыг буулгаж, цэцэрлэгт хүрээлэн авто зогсоол барих болсонтой холбогдуулан тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын баланст бүртгэлтэй, нийт 827,060,531.80 (найман зуун хорин долоон сая жаран мянга таван зуун гучин нэгэн төгрөг наян мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ, 647,264,764.00 (зургаан зуун дөчин долоон сая хоёр зуун жаран дөрвөн мянга долоон зуун жаран дөрөв) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад дурдсан барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Хот байгуулалт, дэд бүтцийн хороо (Б.Сүхбаатар)-нд даалгасугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН



1110100988

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2023.12.31/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуучин барилга	1970	Хан-Уул дүүрэг 20 дугаар хороо	827,060,531.80	179,795,767.80	647,264,764.00	Хотын стандарт, хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны 02-13-01/033/234 дугаар дүгнэлт
Нийт дүн				827,060,531.80	179,795,767.80	647,264,764.00	

_____оОо_____